

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2021 · 12 сар | Дугаар 37

ГАРЧИГ

- 2–4** Бодлогын ярилцлага
- 5–7** Зохицуулалтын мэдээ
- 8** Финтек ба регтек
- 9** Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн
- 10–11** Цуврал хичээл
- 12–15** ББСБ болон ХЗХ–дын системийн эрсдэлийг эрт дохиологч аргачлалаар үнэлэх нь
- 16** Хадгаламж, зээлийн хоршоодын анхаарах засаглалын асуудал
- 17–18** Олон улсын зах зээлийн мэдээ
- 19** Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 📍 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу–3 Засгийн газрын IV байр.
- ☎ 976 51 261611
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.gov.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📱 @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба



Мэндчилгээ

Монгол Улсын санхүүгийн зах зээл дээрх мэргэжлийн оролцогчид, ажилтан, албан хаагчид, салбарын холбоод, харилцагч, үйлчлүүлэгч, иргэд Та бүхэндээ айлчлан ирж буй шинэ жилийн мэнд дэвшүүлье.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах

хүрээнд 5800 гаруй санхүүгийн болон зах зээлийн мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавин ажиллаж байна.

Өнгөрч буй 2021 онд бид шинэ технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн төлөө хичээж ажилласан. Үүний үр дүнд ДНБ–д эзлэх хувь хэмжээ 22.1 хувьд хүрч өссөн. Тэр дундаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 91.0 хувиар өсөж хөрөнгийн зах зээл үүсэж хөгжсөн 30 жилийн түүхэндээ хамгийн дээд түвшинд буюу 12 сарын 16–ны байдлаар 5.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2 дахин, үнэт цаасны арилжаа 28 дахин өслөө. Мөн анх удаа олон улсын бирж хооронд хувьцаа чөлөөтэй хөрвөдөг боллоо. Хөрөнгийн биржээс гадна биржийн бус зах зээлд бүтээгдэхүүн гарах боломжийг бүрдүүлж үйл ажиллагааг нь эхлүүлснээр одоогоор 11 компаниас нийт 189.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна. Биржээр олон нийтэд арилжаалагддаг хамтын сан, анхны төгрөг–валют хосолсон компанийн бонд, нээлттэй арилжаалагддаг буюу хөтөлбөрийн бус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, санхүүгийн технологид суурилсан анхны дижитал бонд, банкны IPO зэрэг шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд ч зах зээлд бий болсон сайхан амжилтаар шинэ оноо угтаж байна.

Цаашид манай хамт олон олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, олон улсын стандартыг нэвтрүүлэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой ногоон санхүүжилтийн үзэл баримтлалыг дэмжих замаар зах зээлийн өсөлтөө хангаж, амжилтаа ахиулахын төлөө хичээж ажиллахдаа Та бүхнийхээ санал, зөвлөмж, оролцоо бүрийг хүлээн авч хамтран ажиллахаа илэрхийлж байна.

Санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэлээ зориулан ажилладаг нийт ажилтан, албан хаагч, хамтран ажилладаг мэргэжлийн холбоод зохицуулалтын байгууллагууд, хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагч үйлчлүүлэгч, иргэд Та бүхэндээ ирж буй шинэ ондоо ажил үйлс тань өөдрөг, амжилт бүтээл дүүрэн, эрүүл, энх байхын өлзийтэй ерөөлийг өргөн барья.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

 Д.БАЯРСАЙХАН



ТАНЫ
САНХҮҮГИЙН
МЭДЛЭГТ

**МЭРГЭЖЛИЙН ХАНДЛАГА –
PROFESSIONALISM**

Монгол: Нийгэм ‘мэргэжилтэн’ хэмээн хүлээн зөвшөөрсөн аливаа этгээд ажил үүргээ гүйцэтгэхдээ баримтлах хандлага, ур чадвар, зан суртахуун, шинж чанар, эрхэмлэх зүйлсийн нэгдлийг илэрхийлсэн нэр.

English: The term professionalism embraces a set of attitudes, skills and behaviours, attributes and values which are expected from those to whom society has extended the privilege of being considered a professional.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг



БОДЛОГЫН ЯРИЛЦЛАГА

СЗХ–НЫ ЗҮГЭЭС САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХЭД ХЭД ХЭДЭН ЧИГЛЭЛД ТӨВЛӨРЧ АЖИЛЛАЛАА



➤ Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/–ноос авч хэрэгжүүлсэн бодлого, түүний үр дүнгийн талаар тус Хорооны Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын ахлах референт П.Байгалмаатай ярилцсаныг хүргүүлж байна.

Иргэд, ААН–үүдийн хувьд цар тахлын нөлөөгөөр хүндхэн жилүүдийг даван туулж байгаа. Санхүүгийн зохицуулах хорооноос эдийн засгийг сэргээх чиглэлээр ямар зохицуулалтууд хийгдэж байна вэ? Энэхүү зохицуулалтуудын үр дүнгийн явц ямар байгаа талаар ярилцлагаа эхлүүлэх үү?

Тэгье. Дэлхий нийтийг хамарч олон хүний амин насанд хүрч, улс орнуудын эдийн засгийг хямрааж байгаа ковид–19 Халдварт цар тахал нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд ч хүмүүсийн ажил, амьдралын хэв маяг, хэрэглэгчийн дадал зуршилд томоохон өөрчлөлтүүд авчирсан бөгөөд санхүүгийн салбарт ч мөн томоохон сорилт шалгалт болсон.

УИХ, Засгийн газар, СЗХ–ноос тулгарч буй хүндрэл, эрсдэлийг даван туулах чиглэлээр маш тодорхой арга хэмжээг тухай бүрт нь авч хэрэгжүүлсэн. Ялангуяа УИХ–ын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /Ковид–19–/ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг

хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх”, УИХ–ын 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”–ийг хэрэгжүүлэх чиглэлээр СЗХ хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний дүнд салбарын хэмжээнд нэлээдгүй ахиц үзүүлсэн.

Ингэхдээ СЗХ улс орнуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, түүний үр дүн, өгөөжийг цаг алдалгүй судалж, өөрийн орны нөхцөлд тохирох эсэхийг тогтоож шийдвэр гаргахад үндэслэл, харгалзах хүчин зүйлс болгон авч үзсэн билээ.

Онцолж зарим ажлаас дурдвал хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах, нийтэд санал болгон гаргах үнэт цаасны шаардлага, шалгуурыг хангахад хүндрэлтэй байгаа жижиг, дунд үйлдвэрлэгч нарт биржийн бус зах зээлээс санхүүжилт татах “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”–ыг баталж, санхүүжилт босгох таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Түүнчлэн үнэт цаасны давхар

бүртгэлийн систем буюу хоёр биржийн хооронд үнэт цаасыг чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах орчныг бүрдүүлснээр Монголын Хөрөнгийн Биржийн зах зээлийн үнэлгээ 5 их наяд төгрөгийг давж түүхэн дээд хэмжээнд хүрлээ.

Монгол Улсад анх удаа олон нийтэд нээлттэй арилжаалах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүллээ. Энэ үйл ажиллагааны хүрээнд цар тахлын эрсдэлтэй нөхцөлд ажилласан 1,177 төрийн албан хаагчдад хамаарах 99.9 тэрбум төгрөгийн түрээслээд өмчлөх орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлээ. Мөн "Инвекстор Актив ТЗК" ХХК нь зээлийн багцаар баталгаажуулсан үнэт цаасаа олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгож анхдагч зах зээлийн арилжааг амжилттай хийсэн.

"Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, бүртгэх журам"–д нэмэлт, өөрчлөлт оруулснаар хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй үнэт цаасыг бирж хооронд, хил дамжуулж хөрвүүлэх цоо шинэ харилцаа бий болж "Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн" ХК нь Монголын Хөрөнгийн биржид, гадаадад, олон улсад Канадын Торонтогийн хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй болж анх удаа хувьцаагаа амжилттай хөрвүүлж хөрөнгийн зах зээлийн хөгжилд шинэ хуудас нээсэн үйл явдал болов.

УИХ–ын хуралдаанаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн баталлаа. Иймээс СЗХ нь банк нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох эрх зүйн орчин бүрдсэнтэй холбогдуулан банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл бууруулах, өмчлөл–удирдлага–хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, олон нийтийн хяналт бий болох зэрэг харьцааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд төвлөрөн ажиллалаа. "Богд банк" хөрөнгийнхөө 20 хувийг олон нийтэд нээлттэй болгож хамгийн анхны нээлттэй хувьцаат компаниар бүртгүүлээд байна.

СЗХ–ноос Даатгалын багц дүрмийн "Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага", "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам"–д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэснээр даатгалын компаниудыг мэргэжлийн хөрөнгө оруулагч болгох, банкны харилцах,

хадгаламжид байршуулдаг дүрмийн сан, нөөц сангийн хөрөнгийн дээд хэмжээг 10 хувиар бууруулж, компанийн өрийн хэрэгсэл болон Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 10 хувиар нэмэгдүүлснээр даатгалын компаниудын олон талт хөрөнгө оруулалтад хөрөнгөө байршуулах боломжийг бүрдүүлсэн ба үүний үр дүнд даатгалын компаниудад хөрөнгийн зах зээлд 200 орчим тэрбум төгрөг хүртэл хөрөнгийг байршуулах боломж бүрдсэн.

Энэ бүхэн СЗХ санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, олон тулгуурт санхүүгийн хөгжүүлэх, зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулагчдыг татах тэдний итгэлийг хадгалах чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалт мөн хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд гэдгийг онцолмоор байна. Энэ бүгдээс харахад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ тус тусдаа дангаар орших бус өөр хоорондоо уялдан хөгжиж, даяарчлах хандлагатай байна.

СЗХ нь санхүүгийн салбарын 4 /Хөрөнгийн зах зээл, Даатгалын салбар, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо/, санхүүгийн бус бизнесийн 2 /Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч/ салбарыг жигд хөгжүүлэхээр ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

СЗХ–ны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу СЗХ нь таны нэрлэсэн 6 салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд 2021 оны байдлаар нийт 5700 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, зохицуулалт тавин ажиллаж байна.

Бид өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн "Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө 2018–2021"–ний хэрэгжилтийг дүгнэж ирэх 2022–2026 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулна. Уг баримт бичиг нь зохицуулалтын салбар тус бүрийн хөгжлийг бие даасан байдлаар дэвшүүлсэн баримт бичгүүд бөгөөд салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх чиглэлд чухал үүрэг гүйцэтгэдэг. Шинээр боловсруулж

буй стратеги төлөвлөгөөнд дээр дурдсанчлан санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь олон салбар, зах зээлийг зэрэг хамрах болж санхүүгийн бүх ажил үйлчилгээг нэг байгууллагын, нэг салбарын хэмжээнд хэмжиж дүгнэх, зохицуулах шаардлага үүссэн тул зах зээлийг бүх түвшинд нь харилцан уялдаатай зохицуулж хөгжүүлэх, эрсдэл даах чадварыг сайжруулах, оролцогч бүх талыг хамарсан эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн санхүүгийн зах зээлийг дунд хугацаанд хөгжүүлэх шинэчлэл, хөгжлийн стратегийг боловсруулна.

Түүнчлэн зохицуулалтад хамрагддаг салбар тус бүрээр төрийн зохицуулагч байгууллагаас авч хэрэгжүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлж, санхүүгийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөөг жил болгон батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

Ирж буй онд СЗХ санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад бодлогын ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?

СЗХ–ны зүгээс санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжихэд хэд хэдэн чиглэлд төвлөрч ажиллаж байна.

Ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчдад хүртээмжтэй банкны тогтолцоог хөгжүүлж, банкны салбарт реформ хийх чиглэлээр Банкны салбарын шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд ирэх оны 06 дугаар сар гэхэд банкны системд нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани, бусад банкнууд хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөнгө хүүлэлтийг хязгаарлах замаар зээлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасны дагуу бичил санхүүгийн хэрэглэгч буюу зээлдэгчийн эрх ашгийг хамгаалж, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэгдсэн сан бий болгох асуудлыг СЗХ–ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.

УИХ–ын 2020 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар /Ковид–19/–ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ"–ний дагуу жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ

эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд, Банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйн зээлд хамрагдах зээлдэгч нарын хүүг хөнгөлөх зардлыг тусгуулсан. Үүний дүнд “Ажлын байрыг дэмжих зээл” зориулалтаар 279 зээлдэгчийн 79.5 тэрбум төгрөгийн зээлд 39.3 тэрбум төгрөгийн батлан даалт гараад байна.

Түүнчлэн Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэний улмаас санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор цаг үеийн шинжтэй бодлого шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байна. Тухайлбал Банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хугацааг хойшлуулсан. Мөн Банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын зээлийн ангилалд өөрчлөлт оруулж, зээлийн ангиллын чанарыг бууруулах хугацааг аажмаар бууруулж мөрдүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн СЗХ-ноос эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан боловсруулсан “Монгол улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах 2021–2025 он хөтөлбөр” нь СЗХ, Монголбанк, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорацийн хамтарсан тушаалаар батлагдаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цаашид хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл рүү татахын тулд хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг сайжруулж хуулийн этгээдийн олон сонголтод хэлбэрийг бий болгохоор ажиллана.

Цар тахал дэгдсэнээс хойш технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ маш хурдтай өсөж байна. Энэ тал дээр ямар зохицуулалт хийгдэж хэрэгжүүлж байна вэ?

Технологид суурилсан шинэ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх, турших улмаар түүний үр дүнд суурилсан зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд СЗХ, СЯ, Монголбанк, Хадгаламж

хамгаалалтын корпорацийн хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг баталсан. СЗХ-нд сэндбоксын орчинд туршилт хийх хүсэлтээ нэр бүхий 9 байгууллага ирүүлсний 7 нь шаардлага хангаагүй буцаагдаж 2-т нь зөвшөөрөл олгоод байна.

Манай улсад холбогдох эрх зүйн зохицуулалт нь бүрдээгүй байхад виртуал хөрөнгийн арилжааны платформ үүсэж, койн гаргаж, олон нийтээс хөрөнгө татахын зэрэгцээ иргэд, олон нийт үүнд хөрөнгө оруулах сонирхол улам нэмэгдсэн. Үүний нэг илрэл нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар 8 төрлийн төлбөр тооцооны болон үнэт цаасны токен гарсан бөгөөд тэдгээрийн арилжааны хэмжээ 1.9 их наяд төгрөгт хүрсэн нь хөрөнгийн зах зээлийн арилжааны хэмжээнээс даруй 60 хувиар өндөр, үйл ажиллагаа эрхэлж буй криптовалютын 5 бирж давхардсан тоогоор 707,826 иргэдэд үйлчилсэн нь цаашид хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах холбогдох эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн болохыг илтгэсэн.

Мөн үүнээс гадна ФАТФ-аас гаргасан зөвлөмжийн дагуу виртуал хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулсан үндэсний хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргийн дагуу СЗХ, ХЗДХЯ, Монголбанк хамтран боловсруулсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай”-ийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэн батлагдаа. Энэхүү хуулийн дагуу дотоодын крипто биржүүд СЗХ болон Монголбанкны бүртгэлд хамрагдах үүрэг хүлээж байна. СЗХ нь хууль батлагдсанаас 4 сарын дотор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах журмыг боловсруулж батлахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын талаар ярилцлага өгсөн танд баярлалаа. Таны цаашдын ажилд амжилт хүсье.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2021 оны IV улирлын ээлжит хурал энэ сарын 13-ны өдөр боллоо. Хуралдааныг Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн даргалж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн болон холбогдох бусад албаныхан оролцлоо.

Хуралдаанаар “Арван их наядын цогц хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон зээлүүдийн хэрэгжилт, түүнд хийгдэж буй хяналтын талаар Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн танилцуулга хийв. Мөн Санхүүгийн мэдээллийн албанаас тус албаны үйл ажиллагааны гүйцэтгэл, виртуал хөрөнгийн салбар дахь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх талаар тус тус танилцууллаа. Улмаар СТБЗ-өөс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд ирэх жилүүдэд хийх ажлуудын хүрээнд зөвлөмж гаргахаар тогтов.

Хуралдааны төгсгөлд СТБЗ-ийн 2022 оны ээлжит хуралдааны хуваарийг баталсан юм.

ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БҮРТГЭЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо нь экспортлогч компаниудад зориулсан төлбөрийн эрсдэлээс хамгаалах нөхцөл бүхий “Экспортын зээлийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг энэ сарын 8-нд бүртгэлээ.

Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн зээлийн санхүүжилтээр 2016 оноос “Экспортыг дэмжих төсөл” хэрэгжиж байгаа билээ. Энэхүү төслийн дэд бүрэлдэхүүн болох “Экспортыг дэмжих санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэх” хүрээнд “Экспортын зээлийн даатгал”-ын бүтээгдэхүүн гаргахаар “Үндэсний давхар даатгал” ХК ажилласан.

Уг бүтээгдэхүүний дотоодын давхар даатгагчаар “Үндэсний давхар даатгал” ХК, харин гадаадын давхар даатгагчаар “Скор” давхар даатгалын компани ажиллах бол андеррайтингийн компаниар “Tinubu square” LLC ажиллахаар төлөвлөсөн.

Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүн ийнхүү зах зээлд нэвтэрснээр экспортлогч компанийн хувьд дансны авлагыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, борлуулалтын эргэлт, бизнесийн ашигт ажиллагаа нь нэмэгдэх, түүнчлэн зээлийн эрсдэл буурах бол Монгол Улсын макро эдийн засгийн хувьд олон улсын экспортын урсгалыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах нөхцөл боломж бүрдэх юм.

БОГД БАНКНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭНЭЭС ДАВЛАА

УИХ-аас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд банкны системд нөлөө бүхий банк нь 2022 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох, бусад банкнуудад нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани байх сонголтыг нээлттэй үлдээсэн.

Тэгвэл энэ оны 11 дүгээр 10-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаанаар банкны системд нөлөө бүхий банканд хамаарахгүй хэдий ч нээлттэй хувьцаат компани болохоор шийдвэрлэсэн “Богд банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэж, олон нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрсөн. Харин 12 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар тус компанийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ татан төвлөрүүлэх дүнгээсээ давж биелээд байна.

Ийнхүү “Богд банк” ХХК нь банкны реформын хүрээнд хамгийн анхны олон нийтийн, нээлттэй хувьцаат компани болох боломжтой боллоо.

“КОМПАЕНСЫН ЭРСДЭЛИЙГ УДИРДАХУЙ” СЭДВЭЭР ХЭЛЭЛЦЛЭЭ



Санхүүгийн салбарын комплаинсын удирдлага нь зөвхөн салбарын асуудал биш бөгөөд үүнд хамааралгүй эдийн засгийн харилцаа, иргэн, аж ахуйн нэгж гэж байдаггүй. Иймээс Санхүүгийн зохицуулах хороо, “Санхүүгийн боловсролын НҮБ” ТББ, Монголын комплаинсын холбоо хамтран “Комплаинсын эрсдэлийг удирдахуй” хэлэлцүүлгийг 12 дугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн

зохицуулах хороо зохицуулалтын байгууллагуудынхаа хяналт, зохицуулалтыг зайны болон газар дээрх дээр нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо хэлбэрээр хийж байсан. Гэтэл 12 дугаар сарын 7-ны өдөр тухайн компанийн бизнесийн хандлагаас гадна үйл хөдлөл нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах,

тэдгээрийн зах зээлд итгэх итгэлийг тогтоох, системийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй болсон. Иймд бид уламжлалт буюу бизнесийн хандлага дээр нь бизнесийн үйл хөдлөлд хяналт тавих нэгдсэн бодлогыг үйл ажиллагаа, хэлбэртээ суулгаад, шинэчлээд явж байна.



ФАТФ буюу Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага Монгол Улсыг стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-д оруулсныг Та бүхэн санаж байгаа. Төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийнхэн нягт хамтарч ажилласны үр дүнд энэ жагсаалтаас маш богино хугацаанд буюу 10 сарын дотор бид гарч чадсан. Гэхдээ цаашид ч бид ФАТФ-ын зөвлөмж, шаардлагуудыг чанд мөрдөж ажиллахын зэрэгцээ санхүүгийн тогтвортой хөгжлийг хангах, үр дүнтэй, тогтвортой тогтолцоог бүрдүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажиллах болно. Энэ бол олон улсын стандарт, журам, заавар хурдацтай өөрчлөгдөж, тавигдах шаардлага өдөр ирэх тусам нарийн болж байгаа өнөөгийн нөхцөлд бидний зайлшгүй анхаарах ёстой асуудал” гэдгийг онцолсон.

Энэхүү хэлэлцүүлгийн зорилго Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай салбаруудад эрсдэлд суурилсан аргачлалыг хэрхэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүрэг, ФАТФ-ын зөвлөмж, стандартыг үр дүнтэй биелүүлэхэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг олох, нэгдсэн ойлголттой болох юм. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хэлэлцүүлгийг танхим, зүүм линк, онлайн лайв хэлбэрээр өрнүүлсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтын салбарын 1000 гаруй холбогдох мэргэжилтэн, удирдах албан тушаалтнууд оролцож санал бодлоо солилцлоо.

Хэлэлцүүлгийн үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, “Санхүүгийн боловсролын HUB” ТББ-ын удирдах зөвлөлийн дарга Р.Амаржаргал нар хамтран ажиллах санамж бичиг үзэглэсэн юм. Хамтын ажиллагааг эхлүүлснээр талууд салбарын эрсдэлийг бууруулж, хөгжлийн шинэ шатанд гаргах урьдач нөхцөлүүдийг бүрдүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн уялдаа холбоог сайжруулах, нийгмийн хариуцлагын хүрээнд сургалтын чанар чансааг сайжруулж салбарын хүний нөөцийг чадавхжуулахад анхаарч ажиллах ажээ.

“БОГД БАНК” IPO ГАРГАЛАА



Санхүүгийн зохицуулах хороо ээлжит хуралдаанаараа “Богд банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэж, олон нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрсөн. Энэ дагуу тус компанийн анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх цан цохих ёслол 12 дугаар сарын 1-ний өдөр боллоо. Ёслолын арга хэмжээнд

УИХ–ын гишүүн Г.Амартүвшин, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК–ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, “Богд банк” ХХК–ийн гүйцэтгэх захирал Г.Саруул болон холбогдох албаны хүмүүс оролцлоо.

Цан цохих ёслолыг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан “УИХ–аас санхүүгийн салбарт бодлогын хоёр чухал баримт бичгийг баталсан. Түүний нэг нь “Зээлийн хүүг бууруулах стратеги” бөгөөд энэ хүрээнд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, үүн дотроо шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээл дээр нэмж гаргах

бодлогын баримт бичгийг гаргасан. Мөн УИХ–аас эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн салбаруудад реформ хийхээр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэснээр системийн нөлөө бүхий банкнууд 2022 оны долоодугаар сарын 01–ний өдөр гэхэд нээлттэй хувьцаат компани болсон байх бусад банкнуудын хувьд нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани байх сонголтыг нээлттэй үлдээсэн. Хэдийгээр нээлттэй хувьцаат компани болох үүргийг хуулиар хүлээгээгүй ч олон нийтийн банк болох үйл ажиллагааг түүхээс орж ирж байгаа “Богд банк” ХХК–ийн хамт олонд юуны өмнө талархал илэрхийлье.



Энэ оны хувьд их онцлог жил. Ялангуяа өнгөрсөн сарын байдлаар Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.2 их наяд төгрөг буюу түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Анхны 1 их наядын үнэлгээтэй үндэсний компани бий болсон, төслийн бус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас арилжаалагдсан. Монголын үндэсний төгрөг болон ам.долларын хосолсон бонд гарсан. Банкны бүтцийн өөрчлөлтөд оролцохоор хамтын хөрөнгө оруулалтын сан нэгж эрхээ амжилттай арилжаалсан. Дээр нь бид бүхэн хос хөтөлбөртэй болсон буюу санхүүжилтийг зөвхөн хөрөнгийн биржээс бус биржийн бус зах зээлээс татах зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо гаргасан зэрэг нэлээдгүй ажлыг хийлээ. Ирэх жилүүдэд ч банкны реформ хийх бөгөөд цаашдаа үндэсний томоохон компаниудыг ч хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, олон нийтийн компани болгохын төлөө зорьж ажиллах болно. Хорооны зүгээс “Үнэт цаасны бүртгэлийн журам”–ыг олон улсын стандартад нийцүүлсэн бөгөөд андеррайтер төвтэй үйл ажиллагааг цаашид хэрэгжүүлнэ” гэдгийг онцолсон юм.

“Богд банк” ХХК нь нийт хувьцааныхаа 20 хувийг буюу 12.5 сая ширхэг хувьцааг нэг бүр нь 2,540 төгрөгөөр нийтэд санал болгох замаар нийт 31.75 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүнээс 70 хувь буюу 8,750,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад, 30 хувь буюу 3,750,000 ширхэг хувьцааг олон нийтэд худалдах юм байна.

ФИНТЕК БА РЕГТЕК

Хиймэл оюун ухааны чатботын Финтекийн салбарт гүйцэтгэх үүрэг

Чатбот нь цахим хуудсууд, мессежийн программууд эсвэл утсаар дамжуулан дижитал тусламж үзүүлдэг хиймэл оюун ухааны программ хангамж юм. Чатбот нь хэрэглэгчдэдээ тохиромжтой, үр дүнтэй үйлчилгээг санал болгож аливаа салбарын үйл ажиллагааны гүйцэтгэлийг дэмждэг зардал багатай систем юм.

Финтекийн шинэ технологиудын ачаар хиймэл оюун ухаан нь үйлчилгээний чанарыг бууруулалгүйгээр асар олон тооны үйлчлүүлэгчдэд нэгэн зэрэг туслахад зориулагдсан. Жишээлбэл мобайл банк болон сүлжээ банкнуудаар дамжуулан хурдан мөнгө шилжүүлэхээс эхлээд төлбөр төлөх, биткойн худалдаж авах гэх мэт ажлыг чатбот ашиглан хийх боломжтой. Хэрэглэгчид цаг хугацаа, эрчим хүч хэмнэхийн зэрэгцээ аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр газарзүйн байршлаас үл хамааран ажлаа амжуулах боломжтой болсон.



24/7 үйлчилгээг шуурхай утасны дугаар, вэб сайт, шуурхай мессежийн тусламж, гар утасны аппликейшн, нийгмийн сүлжээний сувгуудтай нэгтгэж, үйлчлүүлэгчдийн үйлчилгээг ихээхэн нэмэгдүүлэх боломжтой. Энэ үйлчилгээ нь үргэлж холбоотой байж, өндөр мэргэжлийн ур чадварыг санал болгож, дебит эсвэл зээлийн картыг хаах, дансны үлдэгдлийн хураангуй, пин үүсгэх гэх мэт үйлчилгээг үйлчлүүлэгчдэд туслах чухал хэсэг юм.



Хиймэл оюун ухаанаар ажилладаг чатботууд нь хэрэглэгчийн зарцуулалтын зан байдал, гүйлгээний түүхийг шинжлэн түүний ирээдүйн үйлдлийг урьдчилан таамаглаж, санхүүгийн зөвлөгөө өгдөг.



Чатбот нь үйлчлүүлэгчдэд P2P төлбөр болон янз бүрийн төрлийн мөнгө шилжүүлэх үйл явцад тусалдаг. Финтек чатбот дахь автоматжуулалт нь банкны данс эсвэл Paypal, Apple Pay, Paytm төлбөр гэх мэт бусад

дижитал программуудтай холбож төлбөр тооцоо, мөнгө шилжүүлэх, онлайн худалдаа хийх гэх мэт үйл ажиллагааг дэмждэг.



Финтекийн шинэ технологи болох чатботууд нь Facebook, Google, Twitter, youtube, quora зэрэг нийгмийн мэдээллийн платформууд дээр онлайн сурталчилгааны тусламжтайгаар салбарыг хөгжүүлэхэд тусалдаг.



Финтек чатбот хэрэглэгчдэд хувийн санхүүгийн зөвлөгөө, дижитал төлбөр тооцоо болон мөнгөө өсгөхөд нь янз бүрийн аргаар туслах боломжтой. Хиймэл оюун ухаанаар ажилладаг финтек чатботууд нь хэрэглэгчдэд онлайн багц үүсгэх, удирдах болон хадгаламжийн ухаалаг аргуудыг ашиглахад тусалдаг.



Чатботууд нь интерактив даатгал, зээлийн бүтээгдэхүүний шийдлүүдийг илүү олон үйлчлүүлэгчдэд хүргэх зорилготой юм. Үйлчлүүлэгч энгийн бөгөөд тодорхой асуулт тавих хэрэгтэй ба дараа нь чатбот тухайн асуулгад автоматаар хариулж, тэдэнд тохирсон зардал багатай үйлчилгээг санал болгодог, мөн бичиг баримтын бүрдүүлэлтэд тусалдаг.

Чатботууд Финтекийн салбарыг хэрхэн өөрчилж чадах вэ?



Финтекийн аль ч салбарт харилцагчийн үйлчилгээ нь тэдний борлуулдаг бүтээгдэхүүн үйлчилгээтэй адил чухал юм. Хэрэглэгчид өөрт хэрэгтэй бүтээгдэхүүн үйлчилгээгээ хайсны оронд, чатботууд нь тэдний энгийн асуултад хариулсан байдалд үндэслэн идэвхтэй санал өгөх замаар тусалдаг.

Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал нь аливаа бизнесийн хамгийн чухал асуудал бөгөөд тэдний нэр хүнд нь ч хамаардаг. Финтек чатботууд хэрэглэгчийг үр дүнтэй хянаж, залилан мэхлэх үйлдлийг илрүүлж, анхааруулга өгдөг.




Финтекийн чатботууд нь хэрэглэгчдийн оролцоог илүү идэвхтэй болгох зорилготой юм. Чатботоор дамжуулан цуглуулсан мэдээлэл нь компаниудад хэрэглэгчийн сонирхож буй бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгч, тэдэнд шаардлагатай үйлчилгээгээр хангахад тусалдаг.

Финтекийн чатботууд нь маш том хөрөнгө оруулалт болж хувирсан бөгөөд олон агент хөлслөх зардлыг ихээр хэмнэсэн. Энэ нь зөвхөн зардлыг хэмнээд зогсохгүй цаг хугацааг ч хэмнэдэг. AI технологиор ажилладаг Финтек чатботууд нь бизнесийн орлого олоход тусалдаг бөгөөд чатботуудыг нэвтрүүлснээр үйлчлүүлэгчдэдээ нэмүү өртөг шингэсэн үйлчилгээ үзүүлж, тушаалд суурилсан үүргийг харилцан ярианд суурилсан хэсэг болгон өөрчлөх боломжийг олгодог.

Хэрэглэгчид чатботуудын харилцан үйлчлэлд дуртай байдаг учир нь тэд өөрсдийнхөө хэлээр юу хэрэгтэйг төвөггүй асууж чаддаг. Финтек дэх шинээр гарч ирж буй технологиуд нь нэг цэгийн шийдэлд зориулсан чатботуудыг санал болгож, хүлээх хугацааг багасгаж, цахим хуудсуудаар аялах замаар хэрэглэгч бүрд хүрч ажилладаг. Үйлчлүүлэгчийн туршлага сайжирснаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгддэг бөгөөд энэ нь компани үнэнч үйлчлүүлэгчдээс илүү их ашиг олоход хүргэдэг. Финтек чатботоор цуглуулсан бүх өгөгдөл нь компанид харилцаа холбоо, санхүүгийн үр дүнг хэрхэн сайжруулах талаар ойлголт өгдөг.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ



НОГООН

САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
АХЛАХ РЕФЕРЕНТ **Н.НАРАНТУЯА**



санхүүжилтийн бүтээгдэхүүн байсан бол эдүгээ шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд гарах боллоо. Үүнд:

Дээрх ногоон бүтээгдэхүүнүүдийн манай улсын хувьд зах зээл үүсээгүй бүтээгдэхүүн нь дараах болно:

1. Ногоон мортгэйж: Байгаль орчны стандартад нийцсэн ногоон барилга худалдан авах үед олгодог мортгэйжийн зээл.
2. Ногоон байшин эзэмшигчийн зээл: Амьдарч буй үл хөдлөх хөрөнгөдөө эрчим хүчний бага хэрэглээтэй тоног төхөөрөмж суурилуулах зэрэг байшиндаа байгаль орчинд ээлтэй сайжруулалт хийхэд олгодог зээл.
3. Ногоон үнэт цаасжуулалт: Ногоон зээлийг багцлан үнэт цаасжуулах нь уур амьсгалын өөрчлөлтөд уян хатан хандах, нүүрс хүчлийн хий бага ялгаруулах эдийн засаг руу шилжих санхүүжилтээр хангах нэмэлт хөрөнгийн урсгалыг бий болгодог.
4. Шилжилтийн буюу тогтвортой байдлын бонд: Тодорхой шалгуурын дагуу ногоон бондоор хөрөнгө оруулалт татаж чаддаггүй газрын тос, газ, хүнд үйлдвэрүүд уг төрлийн бондоор хөрөнгө оруулалт татдаг.
5. Байгаль орчны компаниуд болон нүүрсхүчлийн хийг бууруулах зээл хөгжүүлэгчдэд венчур капитал хэрэгтэй ба тэдгээрийг олон нийтэд хувьцаагаа гаргахаас өмнө санхүүжилтээр хангаж ашиг олох үе шат хүртэл нь тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь тусалдаг.
6. Ногоон түрээс: Нүүрс хүчлийн хийн ялгарлыг бууруулах тоног төхөөрөмж

түрээслэх ногоон түрээсийн ангилалд дараах хөрөнгүүд хамаарна:

- a. Ногоон эд хөрөнгийн түрээс
- b. Ногоон машины түрээс
- c. Энергийн үр ашиг
- d. Ногоон мортгэйж

7. Уур амьсгалын даатгал: Энэ төрлийн даатгал нь уур амьсгалтай холбоотой санхүүгийн шийдэлд мөнгө босгох боломжийг нэмэгдүүлдэг.



Ногоон эдийн засгийг бий болгох, түүнийг дэмжих санхүүжилтийн орчин нь нэгэн цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Тухайлбал, эрх зүйн орчин, олон нийтийн мэдлэг, мэдээллийн цар хүрээ, иргэд, аж ахуй нэгжүүд ухамсарлан хэрэгжүүлэх нь чухал юм.

Монгол Улс Тогтвортой хөгжлийн 17 зорилтод хүрэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”-ийг боловсруулж, Засгийн газраас 2019 оны 11 дүгээр сард баталж байсан. Уг бодлогын стратегийг хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрэх арга хэмжээний төлөвлөгөөнд нүүрс хүчлийн хийг бууруулах томоохон бүтээн байгуулалт, судалгаа шинжилгээний ажлууд хийгдэх шаардлагатай юм.

Дээрх бүтээн байгуулалтыг 5 жилийн хугацаанд гүйцэтгэх ба гадаадын зээл тусламж, улсын төсөв, хувийн хэвшлийн санхүүжилтийг хамруулаад нийтдээ 20.0 их наяд төгрөг шаардагдах юм. Монгол Улсын хэмжээнд дунджаар жилд 5.0 их наяд төгрөгийн санхүүжилтийг босгосноор хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл, нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг эрчим хүч зэргийг байгуулах боломжтой.

Ногоон санхүүжилтээр хөрөнгө оруулалт татах, санхүүжилт авах эрэлтийг үүсгэдэг гурван хандлага байдаг ба эдгээр нь а) байгаль орчны талаарх мэдлэг, түүнийг хэвлэл мэдээллээр түгээх; б) олон нийтийн байгаль орчны талаарх ухамсар с) байгаль орчны эрх зүйн орчин, зохицуулалт.

Санхүүгийн зах зээлийн хувьд ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн гаргах замаар хөрөнгө оруулалт татах хандлага нийтлэг болсон.

Санхүүгийн зах зээлийн хувьд ногоон зээл, ногоон бонд ногоон бонд, ногоон хөрөнгө оруулалтын сан гэсэн нийтлэг ногоон

ЦУВРАЛ ХИЧЭЭЛ

Үргэлжлэл дараагийн нүүрт

Цуврал №6

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд



ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Даатгал гэдэг нь: Ирээдүйд учирч болох аливаа эрсдэлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа юм.



Даатгагдах эрсдэл



Хувь хүний эрсдэл



Эд хөрөнгийн эрсдэл



Хариуцлагын эрсдэл



Даатгагдахгүй эрсдэл



Элэгдэл, хорогдол



Техникийг шалган турших явцад гарсан хохирол



Сэтгэл санааны хохирол, байгууллагын нэр хүндийн эрсдэл



Даатгал нь даатгалын гэрээний үндсэн дээр иргэд, байгууллагууд эрсдэлээ даатгуулж **даатгалын хураамж төлөх**, гэрээний хүчинтэй хугацаанд **даатгалын тохиолдол** болсон үед даатгалын компаниас **нөхөн төлбөр олгох** үйл ажиллагаа юм.

ХЭРХЭН ӨӨРТ ТОХИРСОН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ЗӨВ СОНГОХ ВЭ?



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

Цуврал №6

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд



ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРӨӨ ХЭРХЭН АВАХ ВЭ?



Даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд



гэрээнд заасан даатгалын тохиолдол гарсан тохиолдолд




нөхөн төлбөрийг даатгагч олгодог.

Жишээлбэл: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдол гарахад таны авах арга хэмжээ:



1. Замын цагдаа, даатгалын компанидаа дуудлага өгөх



2. Ослын улмаас хүн бэртэж, гэмтсэн бол яаралтай түргэн тусламж дуудах



3. Дуудлага өгөх боломжгүй нөхцөлд орчны зураг авах, бичлэг хийх



Даатгуулагч хохирлын нөхөн төлбөрийг төлүүлэхийн тулд дараах баримтыг бүрдүүлэх шаардлагатай.

1. Даатгалын баталгааны эх хувь
2. Даатгуулагчийн өргөдөл
3. Эрх бүхий этгээдийн гаргасан дүгнэлт, акт, материал
4. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт (эмнэлэг, цагдаа г.м)

Нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохгүй байх нөхцөл



1. Санаатайгаар хохирол учруулсан
2. Худал мэдээлэл, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн
3. Гарсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлсэн
4. Гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй
5. Бослого, үймээнд оролцсоны улмаас хохирол үүссэн
6. Гэрээнд заасан хохирлын тохиолдлоос бусад



Зөвлөмж



Даатгалын гэрээг **сайтар уншиж танилцсанаар** гарын үсэг зурах



Даатгагч болон даатгуулагчийн эрх, үүргийг мэддэг байх



Даатгалын нөхөн төлбөр **олгох болон олгохгүй нөхцөлтэй** танилцах



Нөхөн төлбөр олгох хугацаа, маргаан шийдвэрлэх талаар ойлголттой байх

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

СУДЛААЧИЙН ИНДЭР

ББСБ БОЛОН ХЗХ–ДЫН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙГ ЭРТ ДОХИОЛОГЧ АРГАЧЛАЛААР ҮНЭЛЭХ НЬ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн: СЗХ–ны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт **Н.Нарантуяа**
СЗХ–ны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн **С.Будбаяр**

НЭГ. ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Монгол Улсад бичил санхүүгийн салбарт хамаарагддаг Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–ны салбарын системийн хэмжээнд үзүүлэх эрсдэлийн нөлөөг эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалаар тооцон үнэлэхийг зорьсон. Үүний тулд хугацааны цуваан тоон үзүүлэлтийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож түүнээс давсан нөхцөлд системийн эрсдэл, хямрал тохиолдоно гэсэн таамаглал дэвшүүлсэн. Системийн эрсдэл тохиолдох магадлалыг 2009 болон 2017 онд тохиолдсон санхүүгийн мөчлөгийн ёроол цэг тохиолдсон үеийг жишиг болгосон ба бидний тооцсон үнэлгээ нь уг жишигтэй нийцсэн. Судалгааны үр дүнг дүгнэвэл ББСБ–ууд системийн эрсдэлийг үүсгэх магадлал их байдаг ба тус эрсдэл нь хоёр улирал үргэлжилдэг. Харин ХЗХ–оос системийн эрсдэлд харьцангуй мэдрэмж багатай байна.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Эрт дохиологч системийн тооцооллын дохиоллын ба ложит/пробит гэсэн хоёр төрлийн аргачлал байдгаас энэхүү судалгаанд 2009 оны 3 дугаар улирлаас 2020 оны 2 дугаар улирал хүртэлх 44 улирлын ББСБ–уудын хугацааны цувааны тоон мэдээллийг ашиглан Европын төв банкнаас санхүүгийн хямралыг тооцоход тодорхойлсон тоон үзүүлэлтүүд болох 8 бүлгийн 44 үзүүлэлтэд тулгуурлан эрт илрүүлэх дохиоллын системийг ашиглан банк бус санхүүгийн салбарт системийн эрсдэл тохиолдсон эсэхийг үнэлсэн. ХЗХ–

дын хувьд 2009 оны 1 дүгээр улирлаас 2020 оны 3 дугаар улирал хүртэлх 47 улирлын ХЗХ–дын хугацааны цуваан тоон мэдээллийг ашиглан мөн 8 бүлгийн 34 үзүүлэлтэд тулгуурлан үнэлгээ хийв.

Эрт илрүүлэх дохиоллын систем нь хугацааны цуваан үзүүлэлтийн дундаж болон стандарт хазайлтыг тооцоолон уг стандарт хазайлтын тодорхой түвшнээс тухайн улиралд давсан нөхцөлд системийн эрсдэл үүссэнийг таамагладаг аргачлал юм. Системийн эрсдэлийг үнэлэх 8 бүлгийн 44 үзүүлэлт дараах байдалтай байна.

1. Орлогын бүтэц

- Нийт орлогод эзлэх цэвэр орлого
- Нийт орлогод эзлэх хүүгийн бус орлого
- Нийт орлогод эзлэх хураамж ба шимтгэлийн орлого
- Нийт орлогод эзлэх үндсэн үйл ажиллагааны орлого
- Нийт орлогод эзлэх бусад үйл ажиллагааны орлого
- Нийт хөрөнгөд эзлэх нийт үйл ажиллагааны орлого

2. Зардлын бүтэц

- Нийт зардалд эзлэх боловсон хүчний холбогдолтой зардал
- Нийт зардалд эзлэх хүүгийн зардал
- Нийт зардалд эзлэх хүүгийн бус зардал
- Нийт зардалд эзлэх үндсэн бус үйл ажиллагааны зардал

- Нийт зардалд эзлэх зээлийн эрсдэлийн зардал
- Нийт зардалд эзлэх бусад зээлийн эрсдэлийн зардал
- Нийт зардалд эзлэх бусад зардал

3. Ашигт ажиллагааны үзүүлэлт

- Цэвэр ашиг/1–р зэрэглэлийн өөрийн хөрөнгө
- ROA (Активын өгөөж)
- ROE (Хувьцаат капиталын өгөөж)

4. Зохистой харьцааны үзүүлэлт

- Өр төлбөр, өөрийн хөрөнгийн харьцаа
- Өр төлбөр, нийт хөрөнгийн харьцаа
- Өөрийн хөрөнгө, нийт хөрөнгийн харьцаа
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
- 1–р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа
- 1–р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа

5. Хөрөнгийн бүтэц

- Нийт хөрөнгөд эзлэх бэлэн мөнгө
- Нийт хөрөнгөд эзлэх авлага (цэврээр)
- Нийт хөрөнгөд эзлэх зээл (цэврээр)
- Нийт хөрөнгөд эзлэх хөрөнгө оруулалтын үнэт цаас
- Нийт хөрөнгөд эзлэх биет ба биет бус хөрөнгө

- f. Нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн бус хөрөнгө
- g. Нийт хөрөнгөд эзлэх бусад хөрөнгө

6. Өр төлбөрийн бүтэц

- a. Нийт хөрөнгөд эзлэх дотоод гадаадын банк санхүүгийн байгууллагын өглөг
- b. Нийт хөрөнгөд эзлэх итгэлцлийн үйлчилгээний өглөг
- c. Нийт хөрөнгөд эзлэх бусад эх үүсвэр
- d. Нийт хөрөнгөд эзлэх ББСБ-с гаргасан өрийн бичиг
- e. Нийт хөрөнгөд эзлэх Төслийн зээлийн санхүүжилт
- f. Нийт өр төлбөрт эзлэх өөрийн хөрөнгө
- g. Нийт хөрөнгөд эзлэх тайлант үеийн цэвэр ашиг

7. Хөрвөх чадварын үзүүлэлт

- a. Эргэлтийн харьцаа
- b. Мөнгөний харьцаа

8. Хөрөнгийн чанар

- a. Чанаргүй зээлийн хувь
- b. Нийт зээлд эзлэх чанаргүй ба хугацаа хэтэрсэн зээлийн хувь
- c. Өөрийн хөрөнгөд эзлэх чанаргүй ба хугацаа хэтэрсэн зээлийн хувь
- d. Зээл/ДНБ
- e. Гадаад валютаар олгосон зээлийн хувь

Хугацааны цуваагаар илэрхийлсэн үзүүлэлтийг нэгдүгээрт оноожуулалтаар, хоёрдугаарт эрсдэлт хүчин зүйлсийн зураглалаар харууллаа. Үүний тулд 44 улирлын үзүүлэлт тус бүрийн арифметик дунджийг олж, үүний дараагаар дунджаас хазайх хазайлт буюу стандарт хазайлт (σ)–ын утгыг тодорхойлсон. Хасах нэг стандарт хазайлтаас нэмэх нэг стандарт хазайлт буюу $-\sigma < x < \sigma$ хооронд байгаа үзүүлэлтийг аюулгүй буюу ногоон өнгөөр, $-1.5\sigma \leq x \leq -\sigma$ болон $\sigma \leq x \leq 1.5\sigma$ завсар байгаа утгыг анхаарах шаардлагатай буюу шар өнгөөр тэмдэглэсэн. Харин $1.5\sigma < x$ болон $-1.5\sigma > x$ тохиолдолд хямрал үүсэх өндөр магадлалтай гэж үзэн улаан өнгөөр тус тус тэмдэглэсэн.

Зураг 1. Системийн эрсдэлийн зураглалын хэмжигдэхүүн



Жишээ нь: Нийт орлогод эзлэх цэвэр орлогын хэмжээ

2009 оны 3 дугаар улирлаас 2020 оны 2 дугаар улирал хүртэл нийт орлогод эзлэх цэвэр орлогын хувиудыг олж арифметик дундаж болон стандарт хазайлтыг тооцоолсон бөгөөд харгалзан 73.27 хувь, 8.69 хувь байсан. Нийт орлогод эзлэх цэвэр

орлогын хувь нь 73.27 хувиас ± 8.69 хувь (1 стандарт хазайлт) дотор буюу 64.59%–81.96% хооронд бол ногооноор, 60.25%–64.59% эсвэл 81.96%–86.30% хооронд бол шар өнгөөр тэмдэглэгдсэн. Харин 64.59 хувиас эрс бага ба 86.30 хувиас эрс их байгаа тохиолдолд хямрал үүсэх өндөр эрсдэлтэй байгааг илтгэж улаан өнгөөр тэмдэглэсэн.

Зураг 2. Жишээ: Нийт орлогод эзлэх цэвэр орлогын хэмжээ



Системийн эрсдэлийн оноожуулалтыг ногоон бол 0, шар бол 1, улаан бол 1.5 оноогоор үнэлж нийт 44 үзүүлэлтийн онооны нийлбэрийг зурагласан. Харин эрсдэлт хүчин зүйлийн самбараар хугацааны цуваан дахь эрсдэлийн түвшнийг ногоон, шар, улаан өнгөөр илэрхийлсэн болно.


магадлалыг Монгол Улсад өмнө нь тохиолдож байсан мөчлөгийн уналтыг жишиг болгосон. (С.Мягмарсүрэн, 2017) нь судалгааны ажлаараа Монгол Улсын санхүүгийн зах зээлийн мөчлөгийг тооцоолж 2000 оноос хойш санхүүгийн мөчлөгийн 3 оргил, 3 ёроол цэг тодорхойлогдсон бөгөөд бүтэн мөчлөгийн хугацаа нь 5.25 жил гэж дүгнэсэн байна. Энэхүү судалгааны ажилд Монгол улсын санхүүгийн салбарт эрсдэл илүү удаан хугацаагаар, өндөр далайцтай хуримтлагддаг нь ажиглагдсан талаар тусгажээ.


ГУРАВ. ЭМПИРИК СУДАЛГАА

3.1. Банк бус санхүүгийн байгууллагын салбар

Монгол улсын санхүүгийн мөчлөг: Санхүүгийн зах зээл дэх хямрал тохиолдох

Зураг 3. Хямралтай болон хямралын дараах улирлын үзүүлэлтийн төлөв байдал





Хөлгөн датагаар тооцсон эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлал: ББСБ-уудаас үүсэж байгаа системийн эрсдэлийг тэдгээрийн хугацааны цуваан үзүүлэлтээр үнэлсэн бол нэг ББСБ системийн эрсдэлд ямар хэмжээтэйгээр нөлөө үзүүлж болохыг 2020 оны 3 дугаар улиралд хөрөнгийн хэмжээгээр хамгийн их эхний 150 ББСБ-д сонгож авсан 44 үзүүлэлтээр эрт илрүүлэх дохиоллын системийг ашиглан тооцлоо.

Ийнхүү тооцоход салбарын дундаж болон стандарт хазайлтыг 2019 оны 1 дүгээр улирлаас 2020 оны 3 дугаар улирал хүртэлх 7 улирлын статистикаас тооцон харгалзан үзүүлэлт бүрийн эрсдэлгүй, анхаарах шаардлагатай, эрсдэлтэй байх тоон утгыг тодорхойлов.


Эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалаар ББСБ тус бүрийн 8 бүлгийн 44 үзүүлэлтээр тооцсон үр дүнгээс нэг ББСБ

системийн хэмжээнд бага нөлөөтэй ба салбарын бүх ББСБ-уудын эрсдэлүүд нийлж системийн эрсдэлд нөлөөлж буйг харууллаа.

4.2 Хадгаламж, зээлийн хоршоо

ХЗХ-дын хувьд системийн эрсдэл тохиох магадлалыг өмнө дурдсанчлан санхүүгийн мөчлөг тохиож байсан 2009 болон 2016 оноор жишиг тогтоон харьцуулалт хийсэн. ХЗХ-дын 8 бүлгийн 34 үзүүлэлтийг тооцож, эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалын дагуу дундаж, түүнээс хазайх стандарт хазайлтаас 1.5 ба түүнээс ихээр хэлбэлзсэн нөхцөлийг 0-1.5 оноогоор оноонон нийт дүнг харгалзан жишиг онуудтай харьцуулсан. Тус харьцуулалтаас ХЗХ-д системийн эрсдэлд зөвхөн 2009 онд нөлөө бүхий байсан бол түүнээс хойш системийн эрсдэл үүсээгүй байна.

Зураг 6. ХЗХ-доос үүсэх системийн эрсдэлийн оноожуулалт



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Эрт илрүүлэх дохиологч системийн ББСБ-уудын салбарын системийн эрсдэлийг таамаглах байдал нь Монгол Улсад санхүүгийн мөчлөгийн ёроол цэг тохиолдож

байсан үетэй давхцсан тул уг аргачлалаар ББСБ-уудын системийн эрсдэлийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ. Цаашид ББСБ-уудын чанаргүй зээл, хүүгийн түвшин зэрэг чухал үзүүлэлтүүд тодорхой түвшинд

өөрчлөгдөхөд системийн эрсдэлд хэрхэн нөлөөлөх талаар мэдрэмжийн, эсхүл сценарь шинжилгээ хийх, нэг ББСБ-ын системийн хэмжээнд үзүүлэх нөлөөллийг үнэлэх үнэлгээний аргачлалыг сайжруулах саналыг дэвшүүлж байна.

ХЗХ-дын хувьд 2009 оноос хойш системийн эрсдэл ажиглагдаагүй ба энэ нь ХЗХ-д системийн хувьд нөлөө багатайг илтгэнэ. Харин ХЗХ тус бүрийн үүсгэх микро түвшний эрсдэл өндөр байж болзошгүй.

ТАВ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Aldasoro, Icaki, Claudio EV Borio, and Mathias Drehmann. "Early warning indicators of banking crises: expanding the family." BIS Quarterly Review, March (2018).
2. Bhattacharyay, Biswanath, and Gernot Nerb. "Leading indicators for monitoring the stability of asset and financial markets in Asia and the Pacific." Asia Pacific Development Journal 9.2 (2002): 17-50.
3. Bhattacharyay, Biswa N., et al. "Early Warning System for Economic and Financial Risks in Kazakhstan." (2009).
4. Boh, Samo, et al. "Macroprudential database." IFC Bulletins chapters 43 (2017).
5. Danieli, Lorenzo, and Petr Jakubik. Early warning system for the European Insurance Sector. No. 13. EIOPA, Risks and Financial Stability Department, 2018.
6. Dreger, Christian, and Konstantin A. Kholodilin. "An early warning system to predict speculative house price bubbles." Economics: The Open-Access, Open-Assessment E-Journal 7.2013-8 (2013): 1-26. https://www.bis.org/publ/qtrpdf/r_qt1803e.pdf
7. Essien, Sunday Nyong, and Sani Ibrahim Doguwa. "Development and compilation of macroprudential indicators for financial stability and monetary policy in Nigeria." IFC Bulletin 39 (2014).
8. González-Hermosillo, Ms Brenda. Determinants of ex-ante banking system distress: A macro-micro empirical exploration of some recent episodes. International Monetary Fund, 1999.
9. Oet, Mikhail V., et al. "Financial stress index: Identification of systemic risk conditions." 24th Australasian Finance and Banking Conference. 2011. <https://www.imf.org/external/np/pp/eng/2010/090110.pdf>
10. Pasricha, Gurnain, et al. "Assessing financial system vulnerabilities: an early warning approach." Bank of Canada Review 2013.Autumn (2013): 10-19.
11. STANCIU, Lect Cristian. "A review of early warning system models." Finante-provocările viitorului (Finance-Challenges of the Future) 1.11 (2010): 222-228.
12. Vlaar, Peter JG. "Early warning systems for currency crises." BIS conference papers. Vol. 8. 2000. <https://www.bis.org/publ/confer08m.pdf>

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН АНХААРАХ ЗАСАГЛАЛЫН АСУУДАЛ



Хадгаламж, зээлийн хоршоодын талаар олон улсад 2020 онд хийгдсэн судалгаануудаас үзэхэд тэдгээрийн засаглалыг дараах байдалтай гэж дүгнэхээр байна. Үүнд:

Тэргүүлэгчдийн зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн:

- Хадгаламж зээлийн хоршооны Тэргүүлэгчдийн зөвлөлийн /ТЗ/ гишүүдийн төрөлжилтийг нэн тэргүүний ач холбогдол бүхий зорилт гэж тодорхойлсон байна. Тухайлбал, ТЗ-д шинэ гишүүн элсүүлэхэд тавигддаг гол шаардлагад байгууллагын стратегид төвлөрөх чадвар, бие даасан хараат бус сэтгэлгээ зэрэг үр чадварыг хамгийн үнэ цэнтэй гэж дүгнэсэн байна.
- Хадгаламж зээлийн хоршоодын хувьд бусад санхүүгийн салбарынхаас ТЗ нь хүйсийн ялгаатай байдлаараа илүү байдаг. Хадгаламж зээлийн хоршооны ТЗ дунджаар есөн гишүүнтэйгээс гуравны нэг нь эмэгтэй гишүүд байна.

ТЗ-ийн засаглал:

- Засаглалаа бэхжүүлэхэд анхаардаг хоршоодын 1000 гаруй захирлуудын дунд явуулсан судалгаагаар, тэд ТЗ-ийн засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн дараах 4 байр суурийг илэрхийлжээ. Үүнд:
 - а) засаглалыг тогтмол хугацаанд үнэлэх
 - б) засаглалын үнэлгээнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөө
 - в) эрх бүхий албан тушаалтныг сонгох, нутагшуулах үйл явц

д) ТЗ-ийн гишүүдийг сонгох давтамж.

ТЗ-ийн манлайлал:

- Судалгаагаар дараах хоёр ангилалд хуваагдах нийт 7 ТЗ-ийн даргын манлайллын чухал чиг үүргийг тодорхойлсон байна. Үүнд:
 - а) үйл явцыг удирдах (жишээ нь: цаг хуваарилах, хэлэлцэх асуудлын дараалал тогтоох гэх мэт)
 - б) хүнтэй ажиллах (Хороодын гишүүд, дарга нарыг томилох)
- Ихэнх хадгаламж, зээлийн хоршоод ТЗ-ийн даргын томилгооны хугацааг хязгаарладаггүй гэсэн ч судалгаанд оролцсон хадгаламж, зээлийн хоршоодын гуравны нэгээс илүү хувь нь энэ хугацааг хязгаарладаг гэсэн байна. Судалгаагаар ТЗ-ийн даргын томилгооны хугацаа 1–10 жилийн хооронд хэлбэлзэж байв.
- Судалгаанд хамрагдсан ТЗ-ийн нийт гишүүдийн 92% нь гүйцэтгэх захиралтайгаа ажил хэрэгч, үр дүнтэй харилцаатай байна.

Хадгаламж, зээлийн хоршооны стратеги:

- Судалгаанд оролцогчдын 32% нь хадгаламж, зээлийн хоршооны ТЗ байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийг боловсруулахад үр дүнтэй оролцдоггүй гэжээ.
- Хадгаламж, зээлийн хоршоодын төлөөллийн ихэнх нь өдөр тутам гүйцэтгэдэг ажил болон үйл ажиллагааны дотоод хяналтад зарцуулдаг ажлын дундаж цагаа гуравны нэгээр багасгаж, стратегийн төлөвлөлтөд дунджаар 10 хувиар илүү цаг зарцуулах нь зохистой гэж хариулсан байна.

Шийдвэр гаргалт:

- Адармаатай хэцүү асуудал шийдвэрлэх, бие биедээ хариуцлага тооцох, эсвэл бүх гишүүдийг ТЗ-ийн ажилд татан

оролцуулах нь үр дүнгүй байдаг гэж үздэг байна.

- Захирлууд шийдвэр гаргалтын үйл явцад эргэлзэж байсан хэдий ч, тэдгээрийн ихэнх нь ТЗ-ийн гаргасан шийдвэрийг эцсийн дүндээ сайн шийдэл байсан гэдэгт итгэдэг бөгөөд шийдвэрийг хэрэгжүүлэхэд нэгдмэл байр сууринаас хандаж чаддаг байна.

Дээрхээс үзэхэд, хадгаламж, зээлийн хоршооны ТЗ-ийн гишүүд нь стратеги төлөвлөлт болон хараат бус байх асуудалд анхаарал хандуулах шаардлагатай нь судалгаануудын хандлагаас харагдаж байна. ТЗ-ийн гишүүд хэдий эдийн засаг, эрх зүй, санхүү, нягтлан бодох бүртгэл, хүний нөөцийн зэрэг мэргэжилтэй, ажил хэрэгч, мэдлэг чадвартай ч стратегийн төлөвлөлтгүй, бие даасан, хараат бус биш бол Хоршооны үнэ цэн нэмэгдэх боломжгүй аж.

Хадгаламж, зээлийн хоршооны стратегийг боловсруулахад зохих ач холбогдлыг өгч, хангалттай цаг зарцуулж ажиллах шаардлагатай ба энэ нь ТЗ-ийн гол үүрэг хариуцлагын нэг тул үүнийг хэрхэн биелүүлж ажилласнаар нь ТЗ-ийн ажлыг үнэлэх боломжтой. Мөн ТЗ-ийн гишүүдийн төрөлжилт нас, хүйс, арьс өнгө, үндэс угсаа зэрэг хүн ам зүйн ялгаатай байдлын бодлогыг урьд өмнөхөөс илүү анхаарч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн хадгаламж, зээлийн хоршооны засаглалыг сайжруулах зорилгоор ТЗ нь засаглалын үнэлгээг тогтмол хугацаанд хийж, уг үнэлгээнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажилласнаар хадгаламж, зээлийн үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэйгээр явуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх боломжтой.

Эх сурвалж: State of Credit Union Governance, 2020, CU Management

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН **С.БУДБАЯР**

11 дүгээр сарын байдлаар нефтийн үнэ 20 орчим хувиар буурсан.

11 дүгээр сард дэлхийн зах зээлд нефтийн үнэ өнгөрсөн оны 3 дугаар сараас хойш 20 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 11 дүгээр сарын турш “Brent” 17 хувиар, “WTI” 20 хувиар тус тус буурсан. Нефтийн үнэ 2020 оны 3 дугаар сард /Ковид–19 цар тахлын үе/ хамгийн ихээр буюу 50 гаруй хувийг уналтыг үзүүлсэн.

Орос, Хятадын худалдааны эргэлт нэмэгдсэн.



ОХУ, БНХАУ–ын худалдааны хэмжээ 11 дүгээр сард 130.4 тэрбум ам.долларт хүрч, жилийн дундаж үзүүлэлтээс 33.6 хувиар нэмэгджээ.

БНХАУ–ын Гаалийн ерөнхий газраас мэдээлснээр, БНХАУ–аас ОХУ руу хийсэн экспортын хэмжээ 1–11 дүгээр сард 31.3 хувиар нэмэгдэж, 59.4 тэрбум ам.долларт хүрсэн бол Оросын бараа, үйлчилгээний импорт 35.5 хувиар нэмэгдэж, 71.0 тэрбум ам.долларт хүрсэн байна.

“ОПЕК+” 12 дугаар сард олборлолтын төлөвлөгөөгөө үргэлжлүүлэхээр тохиролцсон.

Нефть экспортлогч орнуудын байгууллага /ОПЕК/ болон түүний холбоотнууд /ОПЕК+/ 12 дугаар сард нефтийн олборлолтоо өдөрт 400 мянган торхоор нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцсон байна.

“ОПЕК” болон тус байгууллагын гишүүн бус орнуудын Сайд нарын түвшний 23 дугаар хурал 12 дугаар сарын 2–ны өдөр цахим хэлбэрээр явагдсан юм. “Талууд 2022 оны 01 дүгээр сард 19 дүгээр хурлаар баталсан олборлолтын төлөвлөгөөг үргэлжлүүлэхээр тохиролцлоо. Хамтын ажиллагааны тунхаглалд оролцогч орнууд нефтийн зах зээлийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангахын төлөө туштай ажиллахаа дахин нотолсон” гэж хурлын дараах мэдэгдэлд цохон тэмдэглэжээ. ОПЕК+–ын Сайд нарын түвшний 24 уулзалтыг 2022 оны 1 дүгээр сарын 4–ний өдөр хийхээр товлосон байна.

“Turquoise Hill Resources” компанийн хувьцаа өсжээ.

“Turquoise Hill Resources” компанийн хувьцаа 12 дугаар сарын 13–ны байдлаар 15 хувиар өсжээ. Тус компанийн 51 хувийг эзэмшдэг “Rio Tinto” компани Монголын Засгийн газарт ногдох 2.3 тэрбум ам. долларын өрийг тэглэхээ мэдэгдсэний дараа хувьцааны ханш ийнхүү өссөн байна.

“Rio Tinto” компанийн хувьд Оюу толгой зэс, алтны төслийн бүтээн байгуулалтын ажлаа эрчимжүүлэхээр төлөвлөж буй бөгөөд уг орд нь дэлхийн зэс, алтны хамгийн том уурхайнуудын нэгд тооцогддог юм. Мөн зэсийн хэрэглээний тал хувийг эзэлдэг Хятад улстай ойр оршдог нь тус компанийн хувьд ач холбогдолтой байна.


БНХАУ–ын жижиглэнгийн худалдаа өсжээ.

11 дүгээр сарын 15–ны өдөр БНХАУ–ын статистикийн газраас нийтэлсэн тайланд “11 дүгээр сард тус улсын өргөн хэрэглээний барааны жижиглэнгийн худалдаа 4.1 их наяд юань (644.3 тэрбум орчим ам.доллар) болж, жилийн дундаж үзүүлэлтээс 3.9 хувиар өслөө” гэж нийтэлсэн байна.

Тайлангаас үзвэл, 11 дүгээр сард хөдөө орон нутгийн жижиглэнгийн худалдааны хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 4.8 хувиар өсөж, 570.6 тэрбум юань буюу 89.6 тэрбум орчим ам.доллар болсон ба хот суурин газруудад энэ үзүүлэлт 3.7 хувиар өсөж, 3.5 их наяд юань буюу 554.6 тэрбум орчим ам.долларт хүрчээ.

2021 оны 1–11 дүгээр сард интернэт худалдаа огцом нэмэгдэж 11.9 их наяд юань буюу 1.9 их наяд орчим ам.долларт хүрч, жилийн дунджаас 15.4 хувиар өссөн байна.

Их Британи, Австрали чөлөөт худалдааны гэрээ байгууллаа.



Их Британи ба Австрали Улс нь чөлөөт худалдааны гэрээ байгууллаа. 2021 оны 12 дугаар сарын 16–ны өдөр гэрээнд гарын үсэг зурах ёслол цахим хэлбэрээр зохион Их Британийн Гадаад худалдааны яам мэдээлжээ.

“Их Британи, Австралийн худалдааны хэлэлцээр нь Үндэстнүүдийн Хамтын Нөхөрлөлийн гишүүн болох манай хоёр улсын түүхэн чухал харилцааны онцгой мөч юм. Энэхүү гэрээ нь Их Британийн бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн ашиг сонирхолд нийцүүлэн хийгдсэн бөгөөд улс орон даяар амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд бидэнд тусална. Бид дэлхийн худалдаа, цаг уурын өөрчлөлтөд тулгарч буй сорилтод, мөн удахгүй болох технологийн өөрчлөлттэй холбоотойгоор хариу арга хэмжээ авахад үргэлжлүүлэн хамтран ажиллах болно” гэж Их Британийн Гадаад худалдааны сайд Энн-Мари Тревельян мэдэгдсэн байна. Энэхүү хэлэлцээрийн үр дүнд Их Британийн компаниуд жил бүр 10 тэрбум фунт стерлингийн (13.3 тэрбум ам.доллар) үнэтэй гэрээнүүд байгуулагддаг Австралийн төрийн салбарт төрөл бүрийн бараа, үйлчилгээ нийлүүлэх тендерт оролцох боломжтой болохыг онцолж байна. Үүнээс гадна, Австралид ажил, аялал хийхээр ирсэн 18-

35 насны Британичууд тус улсад гурван жил визгүй зорчих боломжтой болно.

Их Британийн эрх баригчдын тооцоолсноор, хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа улс хоорондын худалдаа 53 хувиар өсөх ч Их Британи Улсын ДНБ ердөө 0.02 хувиар өсөх учир урт хугацаандаа гэрээ нь үр дүр дүнгүй болно гэж таамаглаж байна. Энэ нь Австрали улс Их Британийн нийт экспортын дөнгөж 1.7 хувь, импортын 0.7 хувийг эзэлдэгтэй холбоотой аж.

Японд шатахууны үнэ буурсаар байна.



Японд шатахууны үнэ сүүлийн 5 долоо хоног дараалан буураад байна. “Омикрон” хувилбар эдийн засгийн сэргэлтийг сааруулж болзошгүй нөхцөл байдал үүссэн нь нефтийн фьючерс хэлцлийн үнийг түр хугацаагаар бууруулсан юм.

12 дугаар сарын 15-ны өдөр Японы Нефтийн мэдээллийн төвөөс мэдээлснээр, шатахууны жижиглэнгийн дундаж үнэ 12 дугаар сарын 13-ны байдлаар 165.9 иен буюу нэг доллар 46 цент байсан нь 7 хоногийн өмнөх харьцуулахад 2.1 иенээр буурсан байна.

“Олон нийт “Омикрон” хувилбараас сэргийлэх сонор сэрэмжээ сулруулж эхлээд байгаатай зэрэгцэн, нефтийн эрэлт улирлын нөхцөл байдлаас хамааран дахин нэмэгдэж магадгүй” гэж Нефтийн мэдээллийн төвийн шинжээчид таамаглаж байна.




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 12 дүгээр сарын 17-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,620.64 -48.03 (-1.03%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


29,937.81 -607.87 (-2.13%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,260.60 -146.38 (-2.02%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

15,225.15 -10.72 (-0.07%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо